



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН АВТОБУУДАЛ, НИСЭХ БУУДАЛ, ТӨМӨР ЗАМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ УЯЛДУУЛЖ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУДАЛГАА

Улаанбаатар хот

2021 он

ГАРЧИГ

1. ОРШИЛ
2. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО
3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ
4. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ
5. ОРОН НУТГИЙН НИСЛЭГИЙН СУДАЛГАА
6. СУДАЛГААНЫ ҮР ДҮН
 - БАРУУН БҮСИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН СУДАЛГАА
 - ХАНГАЙН БҮСИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН СУДАЛГАА
 - ТӨВ, БОЛОН ГОВИЙН БҮСИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН СУДАЛГАА
 - ЗҮҮН БҮСИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН СУДАЛГАА
 - НИСЭХ БУУДЛУУДЫН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН СУДАЛГАА
7. ДҮГНЭЛТ

1. ОРШИЛ

Монгол Улс нь 1.564.116 км² өргөн уудам газар нутагтай бөгөөд 21 аймаг, 330 сумдад тархан суурьшсан 3.3 сая хүн амтай. Нийт хүн амын 50% нь Улаанбаатар хотод ажиллаж амьдардаг онцлогтой. Хүн амын үлдсэн 50% нь нийт нутаг дэвсгэрт тархан орон нутагт амьдарч байна. Нийслэл хотоос орон нутаг, орон нутгаас нийслэл хотруу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг авто тээвэр, төмөр зам, агаарын тээврээр оновчтой зохион байгуулах зорчигч урсгалыг нэмэгдүүлэх, хэт төвлөрлийг сааруулах нь улс орны эдийн засагт чухал ач холбогдолтой юм.

Иргэний нисэхийн салбарын бүтцийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын жишигт нийцүүлэн, Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичигт заасны дагуу **үйлдвэрлэл** болон **хяналтын** чиг үүргийг тусад нь салгаж, 2019 оны 12 сарын 26-ны өдрийн ЗТХ-ийн сайдын 387 дугаар тушаалаар Иргэний нисэхийн үндэсний төвийг байгуулсан.

Энэхүү бүтцийн шинэчлэлээр Иргэний нисэхийн үндэсний төв буюу аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулсан нь тус байгууллагын үйл ажиллагааг бизнесийн зарчмаар хөгжүүлэх боломжийг бий болгосон. ИНЕГ-ын харьяа ИНҮТ нь агаарын навигаци, болон нисэх буудал гэсэн 2 үндсэн үйлчилгээг хариуцан ажилладаг бөгөөд агаарын навигаци, нисэх буудлын үйлчилгээгээ сайжруулж, нислэгийн тоог өсгөж, зорчигч урсгалыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Монгол улсын хэмжээнд 2021 оны байдлаар орон нутгийн 22, олон улсын 3 нийт 25 нисэх буудал үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа орон нутгийн 18, олон улсын 2 нисэх буудал, хувийн хэвшлийн харьяа 4 нисэх буудал, Япон Улс, Монгол Улсын хамтарсан олон улсын нисэх буудал 1 байна.

ИНЕГ нь өөрийн эзэмшлийн орон нутгийн нисэх буудлуудаа түшиглэн агаарын тээвэр, авто тээвэр, төмөр замын тээврийг уялдуулан зохион байгуулж, бүсийн зангилаа төвүүдийг байгуулан, билет захиалгын системийн нэгдсэн системийг нэвтрүүлж, орон нутгийн зорчигчдын урсгалыг нэмэгдүүлэх, орон нутгийн нисэх буудлуудыг хөгжүүлэх шийдлийг энэхүү судалгааны ажлаар эрэлхийлсэн болно.

Аэродромын нэр/ Байршил илтгэгч 4 үсгийн код	Аэродромд зөвшөөрөгдсөн нислэгийн төрөл		
	Олон улс-Орон нутгийн (INTL-NTL)	ХНД-ИХНД	S - Хуваарьт NS- Хуваарьт бус P - Хувийн
UVURKHANGAI/Arvaikheer ZMAH	NTL	VFR	NS
GOBI-ALTAI/Altai ZMAT	NTL	IFR-VFR	S, NS
BAYANKHONGOR/Bayankhongor ZMBH	NTL	VFR	S, NS
BULGAN/ Bulgan ZMBN	NTL	VFR	NS
KHOVD/Bulgan sum ZMBS	NTL	VFR	NS
SUKHBAATAR/Baruun-Urt ZMBU	NTL	VFR	NS

Аэродромын нэр/ Байршил илтгэгч 4 үсгийн код	Аэродромд зөвшөөрөгдсөн нислэгийн төрөл		
	Олон улс-Орон нутгийн (INTL-NTL)	ХНД-ИХНД	S - Хуваарьт NS- Хуваарьт бус P - Хувийн
DORNOD/Choibalsan ZMCD	INTL-NTL	IFR-VFR	S, NS, P
ULAANBAATAR/Chinggis Khaan ZMCK	INTL-NTL	IFR-VFR	S, NS, P
KHENTII/Delun boldog ZMDA	NTL	VFR	NS
ZAVKHAN/Donoi ZMDN	NTL	VFR	S, NS
UMNUGOBI/Gurvansaikhan ZMDZ	NTL	IFR-VFR	S, NS
KHUVSGUL/Khatgal ZMHG	NTL	VFR	NS
UVURKHANGAI/Kharkhorin ZMHH	NTL	VFR	NS
UMNUGOBI/Khanbumbat ZMKB	NTL	IFR-VFR	P, S, NS
KHOVD/Khovd ZMKD	NTL	IFR-VFR	S, NS, P
DUNDGOBI/Mandalgobi ZMMG	NTL	VFR	NS
KHUVSGUL/Muren ZMMN	NTL	IFR-VFR	S, NS
NALAIKH/Sky friends ZMSF	NTL	VFR	P, NS
ZAVKHAN/Tosontsengel ZMTL	NTL	VFR	NS
UMNUGOBI/Tavantolgoi ZMTT	NTL	IFR-VFR	P, S, NS
ULAANBAATAR/Buyant-Ukhaa ZMUB	INTL-NTL	IFR-VFR	S, NS, P
UVS/Deglii tsagaan ZMUG	NTL	IFR-VFR	S, NS
KHENTII/Undurkhaan ZMUH	NTL	VFR	NS
BAYAN-ULGII/Ulgii ZMUL	NTL	VFR	S, NS

Хүснэгт 1: Монгол Улсын хэмжээнд нисэхийн мэдээллийн эмхтгэлээр зарлагдан үйл ажиллагаа явуулж байгаа нисэх буудлуудын мэдээлэл

2. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн зорчигч тээврийн авто буудал, нисэх буудал, төмөр замын үйл ажиллагааг уялдуулж үр ашгийг дээшлүүлэх улмаар орон нутгийн зорчигч урсгалыг нэмэгдүүлэх, орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Орон нутгийн зорчигчдын урсгалыг нэмэгдүүлэх агаарын тээвэр, авто тээвэр, төмөр замын үйл ажиллагааг уялдуулан зочигч нь А цэгээс Б цэг хүрэхэд агаарын тээвэр, төмөр зам, авто тээврээр дамжин үйлчлүүлэх боломжийг олгох мөн зорчигчдод цаг хугацаа болон эдийн засгийн үр өгөөжийг бий болгохыг энэхүү судалгааны ажлаар эрэлхийлж байна.

3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү судалгаанд Монгол Улсын нутаг дэвсгэр, авто зам, төмөр зам, агаарын тээврийн үйл ажиллагаа, орон нутгийн зорчигч тээврийн авто буудал, нисэх буудал, төмөр замын буудлуудыг оролцуулан судална.




Зураг 1 : Судалгаанд хамруулах газар нутаг

4. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ


Тус судалгаанд дараах арга зүйг ашиглана.

- Орон нутгийн зорчигч тээврийн тоон мэдээ цуглуулах
- Зорчигчдын тоон мэдээнд дүн шинжилгээ, харьцуулалт хийх
- Авто тээвэр, төмөр зам, агаарын тээврийн хосолсон ложистик тээврийн цогцолбор байгуулах байрлалыг сонгох
- Авто тээвэр, төмөр зам, агаарын тээврийг уялдуулах арга замыг тодорхойлох

5. ОРОН НУТГИЙН НИСЛЭГИЙН СУДАЛГАА



Зураг 2: Орон нутгийн нислэгийн чиглэлүүд



Зураг 3: Орон нутгийн нислэгийн чиглэлүүд бүсээр

Монгол Улсын томоохон суурин газруудын дэд бүтцийн судалгаа
(төв суурин газар, уул уурхай, аялал жуулчлал)

№	Аймаг, сумын нэр	Нисэх буудалтай эсэх	Төмөр замтай эсэх	Хатуу хучилттай авто замтай эсэх	Нийлбэр
1	Архангай	-	-	+	---+
2	Баян-Өлгий	+	-	-	+--
3	Баянхонгор	+	-	+	++-
4	Булган	+	-	+	++-
5	Говь-Алтай	+	-	-	+--
6	Дорноговь	-	+	+	---+
7	Дорнод	+	-	+	++-
8	Дундговь	+	-	+	++-
9	Завхан	+	-	+	++-
10	Өвөрхангай	+	-	+	++-
11	Өмнөговь	+	-	+	++-
12	Сүхбаатар	+	-	+	++-
13	Сэлэнгэ	-	+	+	---+
14	Төв	+	-	+	++-
15	Увс	+	-	-	+--
16	Ховд	+	-	-	+--
17	Хөвсгөл	+	-	+	++-
18	Хэнтий	+	-	+	++-
19	Дархан-Уул	-	+	+	---+
20	Орхон	-	+	+	---+
21	Говьсүмбэр	-	+	+	---+
22	Ховд, Булган	+	-	+	++-
23	Өмнөговь, Овоот	+	-	-	+--
24	Өмнөговь, Тавантолгой	+	+	-	+--
25	Өмнөговь, Оюутолгой	+	-	-	+--
26	Дорнод, Буйр	-	-	-	---
27	Хэнтий, Дэлүүнболдог	+	-	-	+--
28	Өвөрхангай, Хархорин	+	-	+	++-
29	Хөвсгөл, Хатгал	+	-	+	++-
30	Улаанбаатар	+	+	+	+++

Хүснэгт 2: Дэд бүтцийн судалгаа

Дээрх судалгаанаас харахад Улаанбаатар хотоос өөр авто зам, төмөр зам, нисэх буудлын дэд бүтэцтэй газар байхгүй бөгөөд ихэнх аймгийн төвүүд нь хатуу хучилттай замтай, нисэх буудалын дэд бүтэцтэй байна.

Авто зам, төмөр замтай холбогдсон Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Дорноговь аймгийн Замын-Үүд сумдад нисэх буудал байгуулж агаарын тээврийг авто зам, төмөр замтай холбож хилийн боомтод түшиглэсэн зангилаа төвүүдийг байгуулах, хөгжүүлэх боломж харагдаж байна.

6. ОРОН НУТГИЙН НИСЛЭГИЙН СУДАЛГАА

Орон нутгийн нислэгийн зах зээлийн хувьд “МИАТ” ХК, “Аэро Монголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК хуваарьт болон хуваарьт бус нислэг, “Монголиан Эйрвэйс” ХХК, “Скай Такси”, “Томас Эйр” ХХК, “Геосан” ХХК, “Тэнгэрийн Улаач Шинэ” ХХК, “Вельталь Авиа Стар” ХХК захиалгат нислэг тус тус үйлдэж байна.

2020 онд орон нутгийн чиглэлд хуваарьт болон хуваарьт бус нийт 5,563 нислэг үйлдэж 285,674 зорчигч тээвэрлэсэн байна. Хуваарьт нислэгээр 66,677 зорчигч, хуваарьт бус захиалгат нислэгээр 218,997 зорчигч буюу нийт 285,674 зорчигч тээвэрлэсэн байна.

“Аэро Монголиа” ХХК болон “Хүннү Эйр” ХХК-ууд Ховд, Улаангом, Өлгий, Даланзадгад, Мөрөн, Чойбалсан, Улиастай, Алтай, Баянхонгор чиглэлд хуваарьт нислэгийг гүйцэтгэсэн бол Оюутолгой, Овоот, Оюутолгой-Даланзадгад чиглэлүүдэд “МИАТ” ХК, “Аэро Монголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК-ууд хуваарьт бус захиалгат нислэгийг гүйцэтгэсэн байна.

2020 оны байдлаар орон нутагт “МИАТ” ХК (44%), “Аэромонголиа” ХХК (15%), “Хүннү Эйр” ХХК (41%) зэрэг компаниуд хуваарьт болон хуваарьт бус нислэг үйлдсэн байна.

Орон нутгийн зорчигч тээвэрлэлт сүүлийн жилүүдэд тогтмол өсөж ирсэн бөгөөд 2019 оны байдлаар 433.367 зорчигч тээвэрлэж байсан бол 2020 онд Ковид 19 цар тахлаас шалтгаалан 285.674 болж буурсан үзүүлэлттэй байна.

Орон нутгийн зорчигчийн тоо сүүлийн 10 жилд дунджаар 17 хувиар өссөн. Харин 2020 онд орон нутгийн зорчигчийн тоо өмнөх оноос 34 хувиар буюу 147.7 мянган зорчигчоор буурсан үзүүлэлттэй байна.

Орон нутгийн нийт зорчигчийн 23 хувийг нь хуваарьт нислэгийн зорчигч, 77 хувийг захиалгат буюу уул уурхайн чиглэлийн зорчигч эзэлж байна.

Орон нутгийн ачаа, шуудан тээвэрлэлтийн хувьд 2020 онд 35.5 тонн ачаа, 62 тонн шуудан тээвэрлэсэн бөгөөд өмнөх оноос тээвэрлэсэн ачаа 2 хувиар буурч, тээвэрлэсэн шуудан 32 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Орон нутгийн чиглэлд тээвэрлэсэн ачаа, шуудан нь 2009 оноос 2019 оныг дуустал жилийн дундаж өсөлт -4 хувь буюу буурах үзүүлэлттэй байна.

Орон нутгийн зорчигч тээвэрлэлт- чиглэл тус бүрээр

№	Чиглэл	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2020/2019
1	Оюутолгой	86,660	122,916	193,310	262,289	275,466	194,070	-30%
2	Оюутолгой-Даланзадгад	-	-	14,741	20,949	27,053	23,554	-13%
3	Өлгий	14,942	20,223	28,157	28,312	23,960	11,881	-50%
4	Ховд	20,608	20,632	23,597	21,613	23,650	14,961	-37%
5	Мөрөн	11,219	10,413	12,241	16,062	16,863	4,730	-72%
6	Улаангом	14,798	13,602	16,315	14,415	15,177	8,886	-41%
7	Овоот	4,114	4,532	5,239	10,191	14,873	1,373	-91%
8	Даланзадгад	15,422	20,650	11,602	3,242	13,324	70	-99%
9	Алтай	1,565	1,407	1,648	6,929	11,055	13,679	24%
10	Чойбалсан	8,724	7,489	6,821	6,831	6,121	507	-92%
11	Улиастай	9,125	8,700	8,757	7,757	3,409	9,003	164%
12	Баянхонгор	-	43	154	988	2,416	2,518	4%
13	Тавантолгой	1,930	-	-	-	-	-	
14	Хэнтий	80	-	-	-	-	-	
15	Баруун-Урт	6	-	-	-	-	-	
16	Хархорин	48	-	-	-	-	-	
17	Арвайхээр	-	42	-	-	-	-	
18	Тосонцэнгэл	-	-	-	-	-	-	
19	Захиалгат	702	1,937	2,455	2,029	-	442	
Нийт		189,943	232,586	325,037	401,607	433,367	285,674	-34%

Хүснэгт 3: Орон нутгийн зорчигч тээвэрлэлт

Орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагааны өнөөгийн байдал

(АГААРЫН ТЭЭВРИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАСГИЙН ГАРГАСАН НИСЛЭГ, ЗОРЧИГЧИЙН 2020 ОНЫ СУДАЛГААНААС ИШ ТАТАЖ ОРУУЛАВ)

Орон нутгийн зах зээлийн хувьд “МИАТ” ХК, “Аэро Монголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК болон ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчид хуваарьт болон хуваарьт бус нислэг үйлдэж байна.

Орон нутгийн агаарын тээврийн зорчигч тээвэрлэлт 2019 онд 433 мянга байсан бол 2020 онд Ковид-19 цар тахлаас шалтгаалан орон нутгийн зорчигч тээвэрлэлт 285.7 мянга буюу зорчигчийн тоо өмнөх оноос 34 хувиар буурсан үзүүлэлттэй.

Орон нутгийн зорчигч тээвэрлэлт нь 1995 оноос 2019 оныг дуустал буюу 25 жилийн дундаж өсөлт ердөө 4 хувь байна.



График 1: Орон нутгийн чиглэлийн зорчигч тээвэрлэлт

Орон нутгийн зорчигч тээвэрлэлтэд Дэлхийн болон улс орны эдийн засгийн байдал, ДНБ-ний өсөлт нь шууд нөлөөлж байна. Үүнд:

- 2009 он- Дэлхийн эдийн засгийн хямрал нь агаарын тээврийн салбарын орон нутгийн зорчигч тээвэрлэлтэд нөлөөлсөн бөгөөд 2009 онд зорчигчийн тоо өмнөх оноос 25 хувиар, 1995 онтой харьцуулж үзэхэд 44 хувиар тус тус буурчээ.
- 2012 он- Монгол улс 2010 оноос эхлэн ашигт малтмалын баялгаа эдийн засгийн эргэлтэд оруулж, гадаадын хөрөнгө оруулалт болон дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулсны улмаас эдийн засгийн өсөлт 2010 онд 6.4 хувь, 2011 онд 17 хувьд хүрч байсан. Энэхүү эдийн засгийн огцом өсөлт нь 2012 онд орон нутгийн зорчигч тээвэрлэлтэд эерэгээр нөлөөлж, зорчигчийн тоо хамгийн дээд цэгт буюу 340 мянга хүрсэн.

- 2015 он- 2013 оноос дэлхийн зах зээлд нүүрсний үнэ унаж, үүнтэй зэрэгцэн гадаадын хөрөнгө оруулалт багасаж, манай улсын эдийн засаг унасан бөгөөд энэхүү хямралын улмаас 2013-2015 онд орон нутгийн зорчигч тээвэрлэлт жилд дунджаар 20 хувиар буурч байсан.
- 2017 – 2019 онд- Орон нутгийн зорчигч тээвэрлэлт 2017 онд 325 мянга, 2018 онд 401 мянга, 2019 онд 433 мянгад хүрсэн. Оюу Толгой төслийн хоёрдугаар шатны хөрөнгө оруулалт хийгдсэн, далд уурхай ажиллаж эхэлсэн, дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ өссөний улмаас нүүрс олборлогч компаниуд сэргэсэн зэрэгтэй холбоотойгоор агаарын тээвэрлэгчид уул уурхайн чиглэлийн захиалгат нислэг ихээр гүйцэтгэж эхэлсэнтэй холбоотой юм.




График 2: Орон нутгийн зорчигч тээвэрлэлт

Статистик мэдээнээс харахад 2019 оны байдлаар орон нутгийн зорчигчийн тоо өсөх хандлагатай харагдаж байгаа хэдий ч энэ нь уул уурхайн чиглэлийн захиалгат нислэгийн зорчигчийн тооны өсөлттэй холбоотой юм.

Ковид-19 цар тахлын улмаас сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж байсан салбарын үзүүлэлт огцом буурсан ба 2020 оны салбарын тоон үзүүлэлт нь 2009 оны төвшинд хүрээд байна. Олон улсын чиглэлд тээвэрлэсэн зорчигчийн тоо өмнөх оноос 86 хувиар буюу 1 сая 26 мянган зорчигчоор, орон нутгийн чиглэлд тээвэрлэсэн зорчигчийн тоо өмнөх оноос 34 хувиар буюу 147.7 мянган зорчигчоор буурсан үзүүлэлттэй байна.

Орон нутгийн зорчигчийн тоо 2020 онд өмнөх оноос 34 хувиар буурсан бөгөөд нийт орон нутгийн зорчигчийн 77 хувийг уул уурхайн чиглэлийн захиалгат нислэгийн зорчигч эзэлж байна. Орон нутгийн чиглэлд 2019 онд уул уурхайн захиалгат нислэгээр 317,392 зорчигч,

хуваарьт нислэгээр 115,975 зорчигч тээвэрлэсэн бол 2020 онд уул уурхайн захиалгат нислэгийн зорчигчийн тоо 218,997, хуваарьт нислэгийн зорчигчийн тоо 66,677 байна.

Үүнээс харахад 2020 онд орон нутгийн хуваарьт нислэгийн зорчигчийн тоо өмнөх оноос 43 хувиар, уул уурхайн захиалгат нислэгийн зорчигчийн тоо өмнөх оноос 31 хувиар тус тус буурсан байна.

ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ – ЧИГЛЭЛ БҮРЭЭР

Чиглэл	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Баруун бүс												
Өлгий	8,022	13,068	17,677	25,270	25,395	21,774	14,942	20,223	28,157	28,312	23,960	11,881
Алтай	4,235	4,369	12,232	20,460	11,044	14,777	1,565	1,407	1,648	6,929	11,055	13,679
Улиастай	4,272	5,419	6,486	11,039	15,587	13,394	9,125	8,700	8,757	7,757	3,409	9,003
Тосонцэнгэл	-	-	-	138	822	187	-	-	-	-	-	-
Улаангом	7,194	12,336	18,695	21,712	23,736	21,459	14,798	13,602	16,315	14,415	15,177	8,886
Баруунтуруун	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Ховд	9,952	15,343	23,779	31,926	25,432	27,758	20,608	20,632	23,597	21,613	23,650	14,961
Ховдын Булган	-	671	701	735	226	-	-	-	-	-	-	-
Нийт	33,675	51,206	79,570	111,280	102,242	99,349	61,038	64,564	78,474	79,026	77,251	58,410
Хангайн бүс												
Цэцэрлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баянхонгор	2,254	2,192	3,189	6,842	10,375	5,311	-	43	154	988	2,416	2,518
Булган	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Тэшиг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Арвайхээр	188	-	-	23	8	69	48	42	-	-	-	-
Эрдэнэт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Мөрөн	12,275	13,008	16,017	28,621	33,811	31,080	11,219	10,413	12,241	16,062	16,863	4,730
Хатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт	14,717	15,200	19,206	35,486	44,194	36,460	11,267	10,498	12,395	17,050	19,279	7,248
Төвийн бүс												
Мандалговь	-	-	-	27	-	-	-	-	-	-	-	-
Даланзадгад	15,511	17,619	24,947	40,028	39,993	23,811	15,422	20,650	11,602	3,242	13,324	70
Булгагтайн амралт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Овоот	1,547	6,652	15,121	13,550	10,165	8,237	4,114	4,532	5,239	10,191	14,873	1,373
Тавантолгой	-	13,196	27,378	46,358	18,688	4,480	1,930	-	-	-	-	-
Оюутолгой	-	4,815	32,366	73,688	80,121	57,597	86,660	122,916	193,310	262,289	275,466	194,070
Оюутолгой- Даланзадгад	-	-	-	-	-	-	-	-	14,741	20,949	27,053	23,554
Нийт	17,058	42,282	99,812	173,651	148,967	94,125	108,126	148,098	224,892	296,671	330,716	219,067
Зүүн бүс												
Чойбалсан	5,349	6,208	8,590	17,252	18,803	22,838	8,724	7,489	6,821	6,831	6,121	507
Баруун-Урт	128	-	-	108	343	63	6	-	-	-	-	-
Өндөрхаан	-	-	-	62	30	33	80	-	-	-	-	-
Нийт	5,477	6,208	8,590	17,422	19,176	22,934	8,810	7,489	6,821	6,831	6,121	507
Бусад	17,490	24,083	24,361	2,185	10,666	1,496	702	1,937	2,455	2,029	-	442
Орон нутгийн нийт зорчигчийн тоо	88,417	138,979	231,539	340,024	325,245	254,364	189,943	232,586	325,037	401,607	433,367	285,674

ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТӨСӨӨЛӨЛ – 5 ЖИЛЭЭР


Чиглэл	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	Төсөөлөл					
							2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	
Баруун бүс												
Өлгий	14,942	20,223	28,157	28,312	23,960	11,881	14,257	14,781	15,324	15,888	16,472	
Алтай	1,565	1,407	1,648	6,929	11,055	13,679	13,679	13,679	13,679	13,679	13,679	
Улиастай	9,125	8,700	8,757	7,757	3,409	9,003	9,003	9,453	9,926	10,422	10,943	
Тосонцэнгэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Улаангом	14,798	13,602	16,315	14,415	15,177	8,886	9,775	10,263	10,776	11,315	11,881	
Баруунтуруун	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Ховд	20,608	20,632	23,597	21,613	23,650	14,961	17,953	18,851	19,793	20,783	21,822	
Ховдын Булган	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Нийт	61,038	64,564	78,474	79,026	77,251	58,410	64,667	67,028	69,499	72,087	74,797	
Хангайн бүс												
Цэцэрлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Баянхонгор	-	43	154	988	2,416	2,518	2,518	2,394	2,275	2,163	2,056	
Булган	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Төшиг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Арвайхээр	48	42	-	-	-	-	-	-	-	-	-	
Эрдэнэт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Мөрөн	11,219	10,413	12,241	16,062	16,863	4,730	5,676	5,722	5,769	5,816	5,864	
Хатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Нийт	11,267	10,498	12,395	17,050	19,279	7,248	8,194	8,116	8,044	7,979	7,920	
Төвийн бүс												
Мандалговь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Даланзадгад	15,422	20,650	11,602	3,242	13,324	70	700	710	721	731	742	
Булагтайн амралт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Овоот	4,114	4,532	5,239	10,191	14,873	1,373	1,373	1,689	2,077	2,555	3,143	
Тавантолгой	1,930	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Оюутолгой	86,660	122,916	193,310	262,289	275,466	194,070	232,884	279,461	335,353	402,423.55	482,908	
Оюутолгой- Даланзадгад	-	-	14,741	20,949	27,053	23,554	28,265	33,918	40,701	48,842	58,610	
Нийт	108,126	148,098	224,892	296,671	330,716	219,067	263,222	315,778	378,852	454,551	545,403	
Зүүн бүс												
Чойбалсан	8,724	7,489	6,821	6,831	6,121	507	1,014	1,065	1,118	1,174	1,233	
Баруун-Урт	6	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Өндөрхаан	80	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Нийт	8,810	7,489	6,821	6,831	6,121	507	1,014	1,065	1,118	1,174	1,233	
Бусад	702	1,937	2,455	2,029	-	442	530	636	764	917	1,100	
Орон нутгийн нийт зорчигчийн тоо	189,943	232,586	325,037	401,607	433,367	285,674	337,627	392,622	458,278	536,708	630,452	
Өмнөх онтой харьцуулсан өсөлт	-25%	22%	40%	24%	8%	-34%	18%	16%	17%	17%	17%	

БАРУУН БҮСИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ

Агаарын тээврийн салбарын хувьд 1995 онд баруун бүсэд 78 мянган зорчигч тээвэрлэж байсан. Баруун бүсийн зорчигч тээвэрлэлт 2012 онд хамгийн дээд цэгт буюу 111 мянгад хүрч байсан бол 2013 оны эдийн засгийн уналтын улмаас баруун бүсийн зорчигчийн тоо жилд дунджаар 5 хувиар буурсаар 2019 онд зорчигч тээвэрлэлт 77 мянга болсон.

Баруун бүсэд 2020 онд 58 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад зорчигч тээвэрлэлт 24 хувиар буурсан байна.

2019 оны байдлаар баруун бүсийн зорчигчийн тооны дундаж өсөлт -0.07 хувь буюу цаашид зорчигч тээвэрлэлт буурах хандлага ажиглагдаж байна.



Чиглэл	2018 он		2019 он		2020 он	
	Агаарын тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Авто тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Агаарын тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Авто тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Агаарын тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Авто тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/
Баруун бүс	79.0	353.2	77.3	370.5	58.9	265.5

Хүснэгт 4: Баруун бүсийн зорчигч тээвэр (агаарын тээвэр, авто тээвэр)





График 3: Баруун бүсэд тээвэрлэсэн нийт зорчигчид 1995-2020 он

ХАНГАЙН БҮСИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ

Хангайн бүсэд 1995 онд 25 мянган зорчигч тээвэрлэж байсан бөгөөд 2013 онд зорчигчийн тоо хамгийн дээд цэгт буюу 44 мянга хүрчээ. Харин 2014 оноос эхлэн эдийн засгийн уналтын улмаас зорчигчийн тоо жилд дунджаар 27 хувиар буурсаар 2019 оны байдлаар хангайн бүсэд 19 мянган зорчигч тээвэрлэсэн байна.

Тус бүсийн 24 жилийн дундаж өсөлт -1 хувь буюу зорчигчийн тоо цаашид буурах хандлагатай байна.



Чиглэл	2018 он		2019 он		2020 он	
	Агаарын тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Авто тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Агаарын тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Авто тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Агаарын тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Авто тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/
Хангайн бүс	17.1	894.9	19.3	785.7	7.2	876.9

Хүснэгт 5: Хангайн бүсийн зорчигч тээвэр (агаарын тээвэр, авто тээвэр)





График 4: Хангайн бүсийн агаарын тээврийн зорчигчдын тоо 1995-2020 он

ТӨВ БОЛОН ГОВИЙН БҮС ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ

Төвийн бүсэд 1995 онд 10.8 мянга зорчигч тээвэрлэж байсан бөгөөд зорчигч тээвэрлэлт 2017 онд хамгийн дээд цэгт буюу 224.9 мянга хүрсэн байна. Харин 2013 оны эдийн засгийн уналтын улмаас төвийн бүсийн зорчигч тээвэрлэлт буурч байсан хэдий ч 2012-2017 оны дундаж өсөлт 5 хувь байна.

Төвийн бүсийн зорчигч тээвэрлэлт огцом өссөн нь Оюутолгой, Тавантолгой, Овоот чиглэлийн уул уурхайн захиалгат нислэг нэмэгдсэнтэй холбоотой юм.



Чиглэл	2018 он		2019 он		2020 он	
	Агаарын тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Авто тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Агаарын тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Авто тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Агаарын тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Авто тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/
Төвийн бүс	298.7	943.4	330.7	773.1	219.1	561.5

Хүснэгт 6: Төв болон говийн бүсийн зорчигч тээвэр (агаарын тээвэр, авто тээвэр)





График 5: Төв болон говийн бүсийн агаарын тээврийн зорчигч тээвэрлэлт

ЗҮҮН БҮСИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ

Зүүн бүсэд 1995 онд 21.4 мянга зорчигч тээвэрлэж байсан. Зүүн бүсийн зорчигч тээвэрлэлт 2014 онд хамгийн дэд цэгт буюу 22.9 мянгад хүрчээ. Харин 2015 оноос эдийн зорчигчийн тоо буурсаар 2019 онд зорчигч тээвэрлэлт 6.9 мянга болтлоо буурлаа.

Зүүн бүсийн зорчигчийн тооны 24 жилийн дундаж өсөлт -3 хувь буюу цаашид зорчигч тээвэрлэлт буурах хандлага ажиглагдаж байна.



Чиглэл	2018 он		2019 он		2020 он	
	Агаарын тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Авто тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Агаарын тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Авто тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Агаарын тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/	Авто тээврээр зорчсон зорчигчийн тоо /мян.хүн/
Зүүн бүс	6.8	232.8	6.1	217.3	0.5	140.3

Хүснэгт 7: Зүүн бүсийн зорчигч тээвэр (агаарын тээвэр, авто тээвэр)




График 6: Зүүн бүсийн зорчигч тээвэрлэлт 1995-2019 он

Баян-Өлгий аймгийн Өлгий нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Цемент бетон
	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	2850x30
	2400x35
Гэрчилгээний ангилал	II
Хяналтын код	3С
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байхгүй
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/100 хүн

Өлгий нисэх буудлын чиглэлийн тээвэрлэлтийн үзүүлэлт



График 7: Өлгий чиглэлийн зорчигч тээвэрлэлт 1995-2020 он

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зах зээлд нийлүүлсэн суудлын тоо	30,600	43,396	38,276	34,848	23,448
Зорчигчийн тоо	20,223	28,157	28,312	23,960	11,881
Суудал ашиглалт	66%	65%	74%	69%	51%

Увс аймгийн Дэглий цагаан нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Цемент бетон
Хөөрч буух зурвасын хэмжээ	2698x30
Гэрчилгээний ангилал	II
Хяналтын код	3С
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	Байгаа
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/100 хүн

Дэглий цагаан нисэх буудлын чиглэлийн тээвэрлэлтийн үзүүлэлт



График 8: Дэглийцагаан чиглэлийн зорчигч тээвэрлэлт 1995-2020 он

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зах зээлд нийлүүлсэн суудлын тоо	33,700	33,044	24,532	25,036	23,468
Зорчигчийн тоо	13,602	16,315	14,415	15,177	8,886
Суудал ашиглалт	40%	49%	59%	61%	38%

Ховд аймгийн Ховд нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Асфальтон
Хөөрч буух зурвасын хэмжээ	2850x35
Гэрчилгээний ангилал	II
Хяналтын код	4C
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	Байгаа
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/100 хүн

Ховд нисэх буудлын чиглэлийн зорчигч тээвэрлэлтийн үзүүлэлт



График 9: Ховд чиглэлийн зорчигч тээвэрлэлт 1995-2020 он

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зах зээлд нийлүүлсэн суудлын тоо	28,616	45,920	30,324	32,652	25,424
Зорчигчийн тоо	20,632	23,597	21,613	23,650	14,961
Суудал ашиглалт	72%	51%	71%	72%	59%

Ховд аймгийн Булган сум нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	1800x30
Гэрчилгээний ангилал	IV
Хяналтын код	ЗС
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байхгүй
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/50 хүн

Булган сум нисэх буудлын чиглэлд 2015 оноос хойш арилжааны нислэг хийгдээгүй байна.

Завхан аймгийн Тосонцэнгэл нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	2400x30
Гэрчилгээний ангилал	III
Хяналтын код	ЗС
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байхгүй
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/50 хүн

Тосонцэнгэл нисэх буудлын чиглэлд 2015-2020 оны хооронд арилжааны нислэг хийгдээгүй байна.

Завхан аймгийн Доной нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	3228x30
Гэрчилгээний ангилал	III
Хяналтын код	ЗС
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байхгүй
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/100 хүн

Улиастай чиглэлийн тээвэрлэлтийн үзүүлэлт




График 10: Улиастай чиглэлийн зорчигч тээвэрлэлт 1995-2020 он

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зах зээлд нийлүүлсэн суудлын тоо	15,100	13,000	9,900	7,012	20,740
Зорчигчийн тоо	8,700	8,757	7,757	3,409	9,003
Суудал ашиглалт	58%	67%	78%	49%	43%

Говь-Алтай аймгийн Алтай нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Асфальтан
Хөөрч буух зурвасын хэмжээ	2900x30
Гэрчилгээний ангилал	II
Хяналтын код	3С
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	Байгаа
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/100 хүн

Алтай чиглэлийн тээвэрлэлтийн үзүүлэлт



График 11: Алтай чиглэлийн зорчигч тээвэрлэлт 1995-2020 он

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зах зээлд нийлүүлсэн суудлын тоо	3,800	3,500	9,200	16,756	26,960
Зорчигчийн тоо	1,407	1,648	6,929	11,055	13,679
Суудал ашиглалт	37%	47%	75%	66%	51%

Хөвсгөл аймгийн Мөрөн нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Асфальтон
Хөөрч буух зурвасын хэмжээ	2400x42
Гэрчилгээний ангилал	II
Хяналтын код	3С
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байгаа
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/150 хүн

Мөрөн чиглэлийн тээвэрлэлтийн үзүүлэлт



График 12: Мөрөн чиглэлийн зорчигч тээвэрлэлт 1995-2020 он

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зах зээлд нийлүүлсэн суудлын тоо	14,900	18,116	24,916	27,056	19,356
Зорчигчийн тоо	10,413	12,241	16,062	16,863	4,730
Суудал ашиглалт	70%	68%	64%	62%	24%

Хөвсгөл аймгийн Хатгал нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	2300x30
Гэрчилгээний ангилал	IV
Хяналтын код	ЗС
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байхгүй
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/50 хүн

Хатгал нисэх буудлын чиглэлд 2015 оноос хойш арилжааны нислэг хийгдээгүй байна.

Баянхонгор аймгийн Баянхонгор нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Асфальтбетон
Хөөрч буух зурвасын хэмжээ	2800x35
Гэрчилгээний ангилал	II
Хяналтын код	3C
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	Байгаа
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/50 хүн

Баянхонгор чиглэлийн тээвэрлэлтийн үзүүлэлт



График 13: Баянхонгор чиглэлийн зорчигч тээвэрлэлт 1995-2020 он

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зах зээлд нийлүүлсэн суудлын тоо	100	200	1,400	3,200	4,032
Зорчигчийн тоо	43	154	988	2,416	2,518
Суудал ашиглалт	43%	77%	71%	76%	62%

Өмнөговь аймгийн Ханбумбат нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Цемент бетон
Хөөрч буух зурвасын хэмжээ	3250x45
Гэрчилгээний ангилал	III
Хяналтын код	4С
Галын зэрэглэл	7
Аэродромын гэрэл суултын систем	байгаа
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/100 хүн

Оюутолгой чиглэлийн тээвэрлэлтийн үзүүлэлт

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зорчигчийн тоо	122,916	193,310	262,289	275,466	194,070

Өмнөговь аймгийн Овоот нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Цемент бетон
Хөөрч буух зурвасын хэмжээ	2220x30
Гэрчилгээний ангилал	III
Хяналтын код	3С
Галын зэрэглэл	5
Аэродромын гэрэл суултын систем	байхгүй
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/100 хүн

Гурвантэс чиглэлийн нислэгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зорчигчийн тоо	4,532	5,239	10,191	14,873	1,373

Овоотын чиглэлд 2019 онд “Хүннү Эйр” ХХК нь захиалгат нислэг гүйцэтгэж нийт 15 мянган зорчигч тээвэрлэсэн байна.

Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Асфальтон
Хөөрч буух зурвасын хэмжээ	2200x30
Гэрчилгээний ангилал	II
Хяналтын код	3С
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	Байгаа
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/50 хүн

Даланзадгад чиглэлийн тээвэрлэлтийн үзүүлэлт




График 14: Даланзадгад чиглэлийн зорчигч тээвэрлэлт 1995-2020 он

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зорчигчийн тоо	20,650	11,602	3,242	13,324	70

Өмнөговь аймгийн Тавантолгой нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Цемент бетон
Хөөрч буух зурвасын хэмжээ	2220x30
Гэрчилгээний ангилал	III
Хяналтын код	ЗС
Галын зэрэглэл	5
Аэродромын гэрэл суултын систем	байхгүй
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/100 хүн

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зорчигчийн тоо	1,930	-	-	-	-	-

Тавантолгой нисэх буудлын чиглэлд 2015 оноос хойш арилжааны нислэг хийгдээгүй байна.

Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Цемент бетон
Хөөрч буух зурвасын хэмжээ	2597x40
Гэрчилгээний ангилал	II
Хяналтын код	3С
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байгаа
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/120 хүн

Чойбалсан чиглэлийн тээвэрлэлтийн үзүүлэлт



График 15: Чойбалсан чиглэлийн зорчигч тээвэрлэлт 1995-2020 он

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зорчигчийн тоо	7,489	6,821	6,831	6,121	507

Хэнтий аймгийн Өндөрхаан нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	1960x50
Гэрчилгээний ангилал	III
Хяналтын код	ЗС
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байгаа
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/50 хүн

Өндөрхаан чиглэлийн нислэгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зорчигчийн тоо	80	-	-	-	-	-

Өндөрхаан нисэх буудлын чиглэлд 2015 оноос хойш арилжааны нислэг хийгдээгүй байна.

Хэнтий аймгийн Дэлүүнболдог нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	1700x40
Гэрчилгээний ангилал	IV
Хяналтын код	2С
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байхгүй
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/50 хүн

Дэлүүнболдог нисэх буудлын чиглэлд 2015 оноос хойш арилжааны нислэг хийгдээгүй байна.

Булган аймгийн Булган нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	1920x30
Гэрчилгээний ангилал	IV
Хяналтын код	3С
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байхгүй
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/50 хүн

Булган нисэх буудлын чиглэлд 2015 оноос хойш арилжааны нислэг хийгдээгүй байна.

Өвөрхангай аймгийн Арвайхээр нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	2500x50
Гэрчилгээний ангилал	III
Хяналтын код	ЗС
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	Байгаа
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/50 хүн

Арвайхээр нисэх буудлын чиглэлийн үзүүлэлт

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зорчигчийн тоо	48	42	-	-	-	-

Арвайхээр нисэх буудлын чиглэлд 2016 оноос хойш арилжааны нислэг хийгдээгүй байна.

Өвөрхангай аймгийн Хархорин нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	1890x30
Гэрчилгээний ангилал	IV
Хяналтын код	ЗС
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байхгүй
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/50 хүн

Хархорин чиглэлийн нислэгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зорчигчийн тоо	48	-	-	-	-	-

Хархорин нисэх буудлын чиглэлд 2015 оноос хойш арилжааны нислэг хийгдээгүй байна.

Мандалговь нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	1200x30
Гэрчилгээний ангилал	IV
Хяналтын код	2С
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байхгүй
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/50 хүн

Мандалговь нисэх буудлын чиглэлд 2015 оноос хойш арилжааны нислэг хийгдээгүй байна.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт нисэх буудал



Хөөрч буух зурвасын хучилт	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	2210x50
Гэрчилгээний ангилал	III
Хяналтын код	3С
Галын зэрэглэл	4
Аэродромын гэрэл суултын систем	байхгүй
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/50 хүн

Баруун-Урт чиглэлийн нислэгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зорчигчийн тоо	6	-	-	-	-	-

Баруун-Урт нисэх буудлын чиглэлд 2015 оноос хойш арилжааны нислэг хийгдээгүй байна.

Буянт-Ухаа олон улсын нисэх буудал



Монгол Улсын засгийн газрын “Олон улсын нисэх буудлуудын нэрийг өөрчлөх, тэдгээрийн ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 455 дугаар тогтоолоор “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлыг олон улс, орон нутгийн нислэгийн нөөц нисэх буудал, ерөнхий зориулалт, нисэхийн сургалт, захиалгат, онцгой, тусгай үүргийн нислэг, агаарын хөлгийн засвар, үйлчилгээ болон онцгой байдал, иргэний нисэхийн бусад үйл ажиллагаанд ашиглахаар Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяанд ажиллуулахаар шийдвэрлэсэн.

Хөөрч буух зурвасын хучилт	Асфальт бетон
	Шороон зурвас
Хөөрч буух зурвасын хэмжээ	3100x45
	2005x50
Гэрчилгээний ангилал	II
Хяналтын код	3С
Галын зэрэглэл	8
Аэродромын гэрэл суултын систем	байгаа
Нисэх буудлын хүчин чадал	1 цагт/1200 хүн

7. ДҮГНЭЛТ

Зорчигчдын зан төлвийн байдлыг агаарын тээвэр болон авто тээвэртэй харьцуулж үзвэл:

Баруун бүс

Баруун бүсэд агаарын тээврийн тийзний үнэ нь авто тээврийнхээс дунджаар 3-4 дахин их байна. Авто тээврийн тийзний үнэ нь баруун бүсийн дундаж цалин хөлсний 12 орчим хувийг эзэлж, харин агаарын тээврийн тийзний үнэ нь дундаж цалин хөлсний 60 орчим хувийг эзэлж байна.

Алтай болон Доной чиглэлийн хувьд агаарын тээврийн тийзний үнэ нь авто тээврийнхээс 4 дахин их байна. Өлгий, Улаангом болон Ховд чиглэлд агаарын тээврийн тийзний үнэ нь авто тээврийнхээс 3 дахин их байна. Баруун бүсийн дундаж цалин хөлс нь 973 мянган төгрөг бөгөөд тус бүсэд агаарын тээврийн тийзний дундаж үнэ 420 мянга, харин авто тээврийн тийзний дундаж үнэ 120 мянга байна.

Баруун бүсэд 2020 онд агаарын тээврээр нийт 58 мянган зорчигч тээвэрлэсэн бол авто тээврээр нийт 265 мянган зорчигч тээвэрлэсэн байна. Тийзний үнэ, нислэгийн давтамж зэргээс хамаарч ард иргэд нэн яаралтай эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, яаралтай аяллаас бусад тохиолдолд авто тээврийг сонгон үйлчлүүлж байна.

Хангайн бүс

Хангайн бүсийн зорчигч тээвэрлэлт хумигдсан бөгөөд 2008 оноос хойш зөвхөн Мөрөн, Баянхонгор чиглэлд зорчигч тээвэрлэж байна.

Баянхонгорын тийзний үнэ авто тээврийн тарифаас дунджаар 4 дахин, Мөрөнгийн тийзний үнэ авто тээврийн тарифаас 5 дахин их байна.

Авто тээврийн билетний үнэ нь Хангайн бүсийн дундаж цалин хөлсний 10 орчим хувийг эзэлж байна. Харин Баянхонгор чиглэлийн агаарын тээврийн тийзний үнэ нь дундаж цалин хөлсний 40 орчим хувийг, Мөрөнгийн чиглэлийн тийзний үнэ дундаж цалин хөлсний 60 орчим хувийг тус тус эзэлж байна.

Иймд авто замын дэд бүтэц хөгжиж, иргэд хувийн машин болон хот хоорондын зорчигч тээврийн унаагаар үйлчлүүлэх нь нэмэгдсэн байна. Тийзний үнэ, нислэгийн давтамж зэргээс хамаарч ард иргэд нэн яаралтай эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, яаралтай аяллаас бусад тохиолдолд авто тээврийг сонгон үйлчлүүлж байна.

Төв болон говийн бүс

Даланзадгад чиглэлийн тийзний үнэ нь авто тээврийн тарифаас дунджаар 6 дахин их байна. Авто тээврийн билетний үнэ нь Өмнөговь аймгийн дундаж цалин хөлсний 8 орчим хувийг эзэлж, харин агаарын тээврийн тийзний үнэ нь дундаж цалин хөлсний 50 орчим хувийг эзэлж байна.

Иймд тийз үнэ, нислэгийн давтамж зэргээс хамаарч ард иргэд нэн яаралтай эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, яаралтай аяллаас бусад тохиолдолд авто тээврийг сонгон үйлчлүүлж байна.

Даланзадгад чиглэлд 2017 онд агаарын тээврээр 11.6 мянган хүн зорчсон бол авто тээврээр 1.3 сая хүн зорчсон байна.

Зүүн бүс

Чойбалсан чиглэлийн тийзний үнэ нь авто тээврийн тарифаас дунджаар 5 дахин их байна.

Авто тээврийн билетний үнэ нь Дорнод аймгийн дундаж цалин хөлсний 9 орчим хувийг эзэлж, харин агаарын тээврийн тийзний үнэ нь дундаж цалин хөлсний 50 орчим хувийг эзэлж байна.

Иймд тийз үнэ, нислэгийн давтамж зэргээс хамаарч ард иргэд нэн яаралтай эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, яаралтай аяллаас бусад тохиолдолд авто тээврийг сонгон үйлчлүүлж байна.

Бүсийн зангилаа нисэх буудлуудын хэрэгцээ шаардлага:

Ховд, Мөрөн, Гурвансайхан, Чойбалсан нисэх буудлуудыг бүсийн зангилаа нисэх буудал болгон хөгжүүлснээр ажлын байр нэмэгдэж, дэд бүтэц байгуулагдаж, орон нутаг хоорондын нийтийн тээвэр хөгжих, зорчигчдод эдийн засгийн хэмнэлт үүсэх зэрэг нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой.

Өсөн нэмэгдэж буй зорчигчийн эрэлтийг хангахын тулд нисэх буудал болон агаарын тээвэрлэгчид нягт хамтран ажиллаж, агаарын хөлгийн суудал ашиглалтыг олон улсын түвшинд хүргэж, агаарын тээврийн тийзний үнийг дээрх тооцооллын дагуу бууруулан, тогтворжуулах боломжтой. Түүнчлэн аймаг хоорондын агаарын тээвэрт бага оврын агаарын хөлгийн үйлчилгээг нэвтрүүлэх, агаарын хөлөг, авто машин хосолсон тээвэрлэлтийг нэвтрүүлэх нь цаг хугацаа хэмнэх, эдийн засгийн хэмнэлт гаргах замаар зорчигчдын сэтгэл ханамжийг дээшлүүлж, зорчигчдын эрэлт хэрэгцээг хангаж чадна.

Бүсийн зангилаа нисэх буудал болгохын тулд Ховд, Мөрөн, Гурвансайхан, Чойбалсан нисэх буудлууд нь ИНД-139-ийн гэрчилгээжүүлэлтийн III ангиллаас II ангилал буюу бүс нутгийн хэмжээний хуваарьт нислэг үйлдэх, дэд бүтэц сайтай аэродромын ангиллаар гэрчилгээжих шаардлагатай ба “Перрон удирдлагын журам” болон “Нисэх буудлын байгаль орчныг хамгаалах хөтөлбөр”-ийг боловсруулан, батлуулж, нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай.

Дэвшүүлж буй санал:

1. Ховд нисэх буудлыг баруун бүс нутгийн хэмжээнд зангилаа нисэх буудал болгон хөгжүүлэх. Улаанбаатараас эхлэлтэй баруун аймгуудыг чиглэсэн нислэгүүдийг Ховд нисэх буудалд хүлээн авч зорчигчдыг цааш жижиг агаарын хөлөг болон авто тээврээр дамжин зорчих зохион байгуулалтыг хийх.
2. Чойбалсан нисэх буудлыг зүүн бүс нутгийн зангилаа нисэх буудал болгон хөгжүүлэх. Улаанбаатараас зүүн аймгуудыг чиглэсэн нислэгүүдийг Чойбалсан нисэх буудалд хүлээн авч зорчигчдыг ойролцоо байрлах аймаг сумдруу жижиг агаарын хөлөг болон авто тээврээр дамжин зорчих зохион байгуулалтыг хийх.
3. Мөрөн нисэх буудлыг хангайн бүс нутгийн зангилаа нисэх буудал болгон хөгжүүлэх. Улаанбаатараас хангайн бүс нутгуудруу чиглэсэн нислэгүүдийг Мөрөн нисэх буудалд хүлээн авч зорчигчдыг ойролцоо байрлах аймаг сумдруу жижиг агаарын хөлөг болон авто тээврээр дамжин зорчих зохион байгуулалтыг хийх.
4. Гурвансайхан нисэх буудлыг говийн бүс нутгийн зангилаа нисэх буудал болгон хөгжүүлэх. Улаанбаатараас говийн бүс нутгуудруу чиглэсэн нислэгүүдийг Гурвансайхан нисэх буудалд хүлээн авч зорчигчдыг ойролцоо байрлах аймаг сумдруу жижиг агаарын хөлөг болон авто тээврээр дамжин зорчих зохион байгуулалтыг хийх.
5. Баруун аймгуудруу чиглэсэн Улаанбаатар-Алтай-Ховд-Увс-Өлгий-Улаанбаатар гэсэн тойрч нисэх нислэгийн туршилт эхлүүлэх.

6. Зүүн аймгуудруу чиглэсэн Улаанбаатар-Өндөрхаан-Чойбалсан-Баруун-Урт-Улаанбаатар нисэх буудлуудыг тойрч нисэх нислэгийн туршилт эхлүүлэх.
7. Хангайн бүсийн аймгуудруу дамжин нисэх Улаанбаатар-Баянхонгор-Алтай-Улаанбаатар чиглэлийн тойрох нислэгийн туршилт эхлүүлэх.
8. Хангайн бүсийн аймгуудруу дамжин нисэх Улаанбаатар-Мөрөн-Доной-Улаанбаатар чиглэлийн тойрох нислэгийн туршилт эхлүүлэх.
9. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын хилийн боомтыг түшиглэн нисэх буудал байгуулан зорчигчдод авто зам, төмөр зам, агаарын тээврийн цогц үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх.
10. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хилийн боомтыг түшиглэн нисэх буудал байгуулан зорчигчдод авто зам, төмөр зам, агаарын тээврийн цогц үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх.
11. Билет захиалгын нэгдсэн систем
Авто тээвэр, төмөр зам, агаарын тээврийн билет захиалгын нэгдсэн мэдээллийн сан, програм хангамжийг хөгжүүлэн өөртөө үйлчлэх автомат билет захиалгын төхөөрөмжүүдийг нисэх буудал, төмөр замын буудал, авто тээврийн буудлуудад суурилуулж зорчигчдод хаанаас ч агаарын тээвэр, төмөр зам, авто тээврийн билетийг худалдан авах боломжийг бүрдүүлэх.

